



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2021 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 17/2021

Мандалговь

“ШШГГ-аас баруун цагаан дэлгүүр хүртэлх”

1,35 км хатуу хучилттай авто зам,
явган хүний зам, гэрэлтүүлгийн ажлын зураг,
төсөв боловсруулах” зөвлөх үйлчилгээний
ажлыг хүлээн авах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журамын 4.3.4 дүгээр заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй “ШШГГ-аас баруун цагаан дэлгүүр хүртэлх 1,35 км хатуу хучилттай авто зам, явган хүний зам, гэрэлтүүлгийн ажлын зураг, төсөв боловсруулах” зөвлөх үйлчилгээний ажлыг хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Э.Чагнаадорж (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)

Гишүүд:

О.Мөнхзул (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Б.Лхагвасүрэн (Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын дарга)

Э.Энхмэнд (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)

Т.Ганбаяр (Замын цагдаагийн тасгийн ахлах зохицуулагч)

Нарийн бичгийн дарга:

П.Насанхүү (Классик роуд ХХК-ийн захирал)

2. ШШГГ-аас баруун цагаан дэлгүүр хүртэлх 1,35 км хатуу хучилттай авто зам, явган хүний зам, гэрэлтүүлгийн ажлын зураг, төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг хүлээн авч, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ажиллахыг комиссын дарга (Э.Чагнаадорж)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *И.С.Б.* Л.ДОРЖБАТ

4822150532